БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## БАЯН-ОВОО СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**АУДИТЫН КОД:** БНА-2021/31/СТА-ТШЗ

Баянхонгор
2021 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням

Утас: 88011833 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

“Баянташаагийн эх аудит” ХХК-ний аудитор: Т.Хоролсүрэн

Утас: 99116028 Цахим хаяг: bte.audit@yahoo.com

Цахим хуудас: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

√

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Агуулга


1.Төрийн аудитын санал, дүгнэлт /Эх хувь/ .... 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.... 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .... 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .... 6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .... 7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .... 9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .... 9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .... 10
3.Аудитын тайлан .... 12
3.1. Ерөнхий зүйл .... 12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.... 12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.... 13
3.4. Материаллаг байдал.... 13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .... 13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.... 14
3.7. Шилэн дансны мэдээлэл .... 15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .... 16
3.9. Аудитын илрүүлэлт .... 16
Залруулсан алдаа .... 16
Аудитын зөвлөмж .... 16
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.... 16
4. Менежментийн захидал.... 16
6 Хавсралт. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .... 18




ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 005 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2021.02.25 № 2/155

танай ______________ -ны № ______________ -т

БАЯН-ОВОО СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
С.ОТГОНЖАРГАЛ ТАНАА

# АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

## Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баяновоо сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баяновоо сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

## Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

## Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус Эрүүл мэндийн төв нь Баяновоо сумын Засаг дарга, Аймгийн Эрүүл мэндийн газартай хамтарсан гэрээ байгуулан ажиллаж, сүүлийн хагас жилийн гэрээ 96,5 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

Аудитын хүрээнд бусад асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

2021 А4 ТООТ

005020157

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **13,819,829.17** | **11,672,035.01** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 13,819,829.17 | 11,672,035.01 |
| **354** | **Хангамжийн материал** | 13,819,829.17 | 11,672,035.01 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,145,790.00 | 12,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 5,656,600.00 | 94,300.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 603,759.17 | 800,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 710,180.00 | 947,905.01 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 4,703,500.00 | 9,817,830.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **457,614,902.71** | **440,752,374.21** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 457,614,902.71 | 440,752,374.21 |
| **392** | **Биет хөрөнгө** | 440,466,569.51 | 422,448,374.17 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 409,212,162.00 | 409,212,162.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -27,063,632.42 | -44,989,467.74 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 35,100,000.00 | 35,100,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -10,362,198.77 | -16,842,198.77 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 87,653,471.00 | 97,751,898.19 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -61,517,647.00 | -67,898,254.55 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 13,260,925.30 | 17,043,925.30 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -5,816,510.60 | -6,929,690.26 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 17,148,333.20 | 18,304,000.04 |
| 39301 | Програм хангамж | 440,000.00 | 880,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -203,666.80 | -87,999.96 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 16,912,000.00 | 17,512,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **471,434,731.88** | **452,424,409.22** |
| **413** | **Өглөг** | 00.00 | 9,416,649.20 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 00.00 | 9,375,649.20 |
| **4136** | **Бусад өглөг** | 00.00 | 41,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 00.00 | 41,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **471,434,731.88** | **443,007,760.02** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 471,434,731.88 | 443,007,760.02 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 235,794,363.56 | 235,794,363.56 |
| 51101 | Өмч: - төрийн | 235,794,363.56 | 235,794,363.56 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -125,282,908.15 | -153,709,880.01 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -125,282,908.15 | -125,282,908.15 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -28,426,971.86 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 360,923,276.47 | 360,923,276.47 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **471,434,731.88** | **452,424,409.22** |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **367,852,081.00** | **435,089,986.57** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,031,600.00** | **32,937,242.57** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,031,600.00 | 32,937,242.57 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,031,600.00 | 32,937,242.57 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1,031,600.00 | 32,937,242.57 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **366,820,481.00** | **402,152,744.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 311,586,400.00 | 322,287,800.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 311,586,400.00 | 322,287,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 3,700.00 | 19,584,984.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,700.00 | 19,584,984.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 37,258,100.00 | 33,258,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 37,258,100.00 | 33,258,100.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 17,972,281.00 | 27,021,860.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 815,281.00 | 00.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 17,157,000.00 | 27,021,860.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **385,832,724.94** | **463,898,950.22** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **385,832,724.94** | **463,898,950.22** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 384,432,836.45 | 437,516,268.20 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 222,247,433.00 | 268,953,462.00 |
| 210101 | Үндсэн цалин | 221,251,433.00 | 187,141,462.00 |
| 210102 | Нэмэгдэл | 996,000.00 | 63,627,600.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 18,184,400.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 27,780,929.06 | 33,435,258.86 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,891,030.70 | 23,110,943.29 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,222,472.84 | 2,718,935.16 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,777,979.67 | 2,168,427.53 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 444,495.17 | 494,269.81 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,444,950.68 | 4,942,683.08 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 31,338,432.12 | 34,307,546.12 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,466,762.12 | 4,227,996.12 |
| 210302 | Түлш, халаалт | 28,492,170.00 | 29,557,550.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 379,500.00 | 522,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 23,790,598.57 | 25,617,428.17 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,590,830.00 | 4,384,190.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,115,760.57 | 9,114,799.17 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,980,000.00 | 2,055,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 7,104,008.00 | 10,063,439.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 33,450,955.45 | 33,195,670.57 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 26,023,084.00 | 23,359,035.58 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210502 | Хоол, хүнс | 5,326,871.45 | 4,543,234.99 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,101,000.00 | 5,293,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,392,000.00 | 619,860.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,392,000.00 | 619,860.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,617,000.00 | 1,538,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,617,000.00 | 1,538,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 80,000.00 | 400,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 80,000.00 | 00.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 400,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 39,735,488.25 | 39,449,042.48 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,359,444.00 | 6,843,095.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 31,376,044.25 | 32,605,947.48 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,399,888.49 | 26,382,682.02 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,070,056.00 | 19,573,284.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 1,070,056.00 | 00.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 19,573,284.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 30,867.88 | 1,814,153.88 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 27,167.88 | 1,802,453.88 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 298,964.61 | 4,995,244.14 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 298,964.61 | 4,995,244.14 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-17,980,643.94** | **-28,808,963.65** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | 00.00 | 581,658.29 |
| 145002 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз | 00.00 | 581,658.29 |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 305,651.11 | 199,666.50 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 305,651.11 | 199,666.50 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -305,651.11 | 381,991.79 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-18,286,295.05** | **-28,426,971.86** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **366,820,481.00** | **402,152,744.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **366,820,481.00** | **402,152,744.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 311,586,400.00 | 322,287,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 3,700.00 | 19,584,984.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,700.00 | 19,584,984.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 37,258,100.00 | 33,258,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 37,258,100.00 | 33,258,100.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 17,972,281.00 | 27,021,860.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 815,281.00 | 00.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 17,157,000.00 | 27,021,860.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **357,870,881.00** | **395,252,844.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **357,870,881.00** | **395,252,844.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **356,725,767.51** | **368,870,161.98** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 222,818,748.39 | 266,654,220.86 |
| 210101 | Үндсэн цалин | 167,054,977.62 | 184,842,220.86 |
| 210102 | Нэмэгдэл | 43,265,735.15 | 63,627,600.00 |
| 210104 | Урамшуулал | 12,498,035.62 | 18,184,400.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 28,357,500.00 | 35,734,500.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,940,300.00 | 25,068,300.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,354,300.00 | 2,666,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,883,400.00 | 2,133,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 470,900.00 | 533,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,708,600.00 | 5,333,100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 34,250,932.12 | 30,495,046.12 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,466,762.12 | 4,227,996.12 |
| 210302 | Түлш, халаалт | 31,392,170.00 | 25,867,050.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 392,000.00 | 400,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 14,573,850.00 | 12,188,035.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 977,300.00 | 1,199,625.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,007,500.00 | 6,861,360.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,992,000.00 | 1,851,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,597,050.00 | 1,998,350.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 00.00 | 950,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 30,568,159.00 | 12,598,660.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 23,920,659.00 | 6,041,800.00 |
| 210502 | Хоол, хүнс | 4,637,500.00 | 4,546,860.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,010,000.00 | 2,010,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,790,000.00 | 1,010,700.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 50,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,790,000.00 | 960,600.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,617,000.00 | 1,538,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,617,000.00 | 1,538,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,152,400.00 | 400,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,152,400.00 | 00.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 400,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 18,597,178.00 | 8,678,700.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 18,597,178.00 | 8,678,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,145,113.49** | **26,382,682.02** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 815,281.00 | 19,573,284.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 815,281.00 | 00.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 19,573,284.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 30,867.88 | 1,814,153.88 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 27,167.88 | 1,802,453.88 |
| 213405 | Төвлөрүүлэх шилжүүлэг нэмэлт | 3,700.00 | 11,700.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 298,964.61 | 4,995,244.14 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 298,964.61 | 4,995,244.14 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **8,949,600.00** | **6,899,900.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **8,949,600.00** | **6,899,900.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **8,949,600.00** | **6,899,900.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 8,949,600.00 | 6,899,900.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 8,949,600.00 | 6,899,900.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-8,949,600.00** | **-6,899,900.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **235,794,363.56** | **360,923,276.47** | **-125,282,908.15** | 471,434,731.88 |
| D01 | **2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **235,794,363.56** | **360,923,276.47** | **-125,282,908.15** | 471,434,731.88 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **235,794,363.56** | **360,923,276.47** | **-125,282,908.15** | 471,434,731.88 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -28,426,971.86 | -28,426,971.86 |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **235,794,363.56** | **360,923,276.47** | **-153,709,880.01** | 443,007,760.02 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайланд оны | | Зөрүү | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Дүн | Хувь |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **382,574,600.00** | **375,770,061.98** | **(6,804,538.02)** | **98.22** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **382,574,600.00** | **375,770,061.98** | **(6,804,538.02)** | **98.22** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **382,574,600.00** | **375,770,061.98** | **(6,804,538.02)** | **98.22** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **266,656,200.00** | **266,654,220.86** | **(1,979.14)** | **100.00** |
| 210101 | Үндсэн цалин | 184,843,700.00 | 184,842,220.86 | (1,479.14) | 100.00 |
| 210102 | Нэмэгдэл | 63,628,100.00 | 63,627,600.00 | (500.00) | 100.00 |
| 210104 | Урамшуулал | 18,184,400.00 | 18,184,400.00 | - | 100.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **35,734,500.00** | **35,734,500.00** | **-** | **100.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,068,300.00 | 25,068,300.00 | - | 100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,666,600.00 | 2,666,600.00 | - | 100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,133,200.00 | 2,133,200.00 | - | 100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 533,300.00 | 533,300.00 | - | 100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,333,100.00 | 5,333,100.00 | - | 100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **32,258,100.00** | **30,495,046.12** | **(1,763,053.88)** | **94.53** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,395,700.00 | 4,227,996.12 | (167,703.88) | 96.18 |
| 210302 | Түлш, халаалт | 27,462,400.00 | 25,867,050.00 | (1,595,350.00) | 94.19 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 400,000.00 | 400,000.00 | - | 100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **14,308,400.00** | **12,860,335.00** | **(1,448,065.00)** | **89.88** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,200,000.00 | 1,199,625.00 | (375.00) | 99.97 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,142,400.00 | 6,861,360.00 | (1,281,040.00) | 84.27 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,016,000.00 | 1,851,000.00 | (165,000.00) | 91.82 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,000,000.00 | 1,998,350.00 | (1,650.00) | 99.92 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 950,000.00 | 950,000.00 | - | 100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **13,889,200.00** | **12,598,660.00** | **(1,290,540.00)** | **90.71** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 7,129,200.00 | 6,041,800.00 | (1,087,400.00) | 84.75 |
| 210502 | Хоол, хүнс | 4,750,000.00 | 4,546,860.00 | (203,140.00) | 95.72 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,010,000.00 | 2,010,000.00 | - | 100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **9,111,500.00** | **6,810,600.00** | **(2,300,900.00)** | **74.75** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 8,111,500.00 | 5,850,000.00 | (2,261,500.00) | 72.12 |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 960,600.00 | (39,400.00) | 96.06 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **1,538,000.00** | **1,538,000.00** | **-** | **100.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,538,000.00 | 1,538,000.00 | - | 100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **400,000.00** | **400,000.00** | **-** | **100.00** |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 400,000.00 | 400,000.00 | - | 100.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **8678700** | **8678700** | **-** | **100.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,678,700.00 | 8,678,700.00 | - | 100.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **382,574,600.00** | **375,770,061.98** | **(6,804,538.02)** | **98.22** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **322,287,800.00** | **317,292,555.86** | **(4,995,244.14)** | **98.45** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 322,287,800.00 | 317,292,555.86 | (4,995,244.14) | 98.45 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **33,258,100.00** | **31,455,646.12** | **(1,802,453.88)** | **94.58** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 33,258,100.00 | 31,455,646.12 | (1,802,453.88) | 94.58 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **27,028,700.00** | **27,021,860.00** | **(6,840.00)** | **99.97** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 27,028,700.00 | 27,021,860.00 | (6,840.00) | 99.97 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **0** | **0** | **-** | **0.00** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **0** | **0** | **-** | **0.00** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1** | **1** | **-** | **100.00** |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | - | 100.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **22** | **21** | (1.00) | **95.45** |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 14 | 13 | (1.00) | 92.86 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 7 | 7 | - | 100.00 |
| **64** | **ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО** | **1,432.00** | **1,432.00** | **-** | **100.00** |
| 640001 | Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо | 263 | 263 | - | 100.00 |
| 640002 | Улсын эмнэлгийн амбулатороор эмчлүүлэгсдийн тоо | 1,169.00 | 1,169.00 | - | 100.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **22** | **21** | **-** | **95.45** |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 15 | 14 | (1.00) | 93.33 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 7 | 7 | - | 100.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл | |
|---|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **19,573,284.00** | |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **19,573,284.00** | |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 0.00 | 19573284.00 | |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 19,573,284.00 | |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 19,573,284.00 | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 19573284.00 | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 19,573,284.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 19,573,284.00 | |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга С.Отгонжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 18-аас 2021 оны 02 дугаар сарын 25–ны хооронд “Баянташаагийн эх аудит” ХХК-ний аудитор Т.Хоролсүрэн Ч.Чимгээ нар хариуцаж хэрэгжүүлэв.

Тус Эрүүл мэндийн төв нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх хүсэлтийг Төрийн Аудитын газарт мөн оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 118 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэдний эрэлт, хэрэгцээнд тулгуурлан аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношилгоо, эмчилгээний шинэ тогтолцоог бүрдүүлэх замаар тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан ард иргэдийг эрүүлжүүлэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2020 онд харьяа орон нутаг дахь Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "Дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 385832,7 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 7716,6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 463898,9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 9277,9 мянган төгрөгөөр тооцов.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 577499,9 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 14921,4 мянган төгрөгөөр буюу 2,5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө,өглөгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 13,819.8 | 11,672.0 | (2,147.8) |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | - | - |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 13,819.8 | 11,672.0 | (2,147.8) |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 457,614.9 | 440,752.4 | (16,862.5) |
| Үндсэн хөрөнгө | 562,578.6 | 577,500.0 | 14,921.4 |
| Хуримтлагдсан элэгдэл | (104,963.7) | (136,747.6) | (31,784.0) |
| **Нийт хөрөнгө** | 471,434.7 | 452,424.4 | (19,010.3) |
| Өр төлбөр | - | 9,416.6 | 9,416.6 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 471,434.7 | 443,007.8 | (28,427.0) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 471,434.7 | 452,424.4 | (19,010.3) |

*Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан*



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Тайлант онд эргэлтийн хөрөнгө 11672,03 мянган төгрөг болж, 2147,8 мянган төгрөгөөр буурсан нь бараа материалын үлдэгдэл буурсантай холбоотой.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 577500 мянган төгрөг болж 14921,4 мянган төгрөгөөр өссөн тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийн үлдэгдэл өссөнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 443007,8 мянган төгрөг болж 28427,0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 435089,9 мянган төгрөг болж, өмнөх оноос 67237,9 мянган төгрөгөөр буюу 18 хувиар өссөн байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээж авсан орлого өмнөх оноос 31905,6 мянган төгрөгөөр нэмэгдсэн болон тайлант онд тусламж санхүүжилтийн орлого 35322,3 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Тусламж санхүүжилтийн орлогыг нэр төрлөөр авч үзвэл тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт 10701,4 мянган төгрөгөөр өссөн, орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт 4000 мянган төгрөгөөр буурсан, нэмэлт санхүүжилт 15884,9 мянган төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 9864,8 мянган төгрөгөөр тус тус нэмэгджээ.

Бараа үйлчилгээний нийт зардал 437516,2 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 53083,4 мянган төгрөгөөр буюу 13,8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардал 46706,0 мянган, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 2969,1 мянган, хангамж бараа материалын зардал 1826,8 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, бараа үйлчилгээний бусад зардал 1516,4 мянган буурсантай холбоотой байна.

## 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд салбарын онцлогийг тусгасан сумын хүн амын болон багийн тоо, үйлчилгээний радиус, аймгийн төвөөс алслалтыг төлөвлөснөөс гадна цалингийн зардалд 280329,8 мянган, тогтмол зардалд 32655,9 мянган, урсгалд зардалд 3180,0 мянган, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан 5 ажилтны 19573,2 мянган төгрөгийг төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1999,9 мянган төгрөгөөр бууруулж, 384574,6 мянган төгрөгөөр батлагдсанаас 2 удаа тодотгол хийгдэж, тухайн онд 382574,6 мянган төгрөгөөр төсвийг баталсан байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 382574,6 мянган төгрөгийн төсөв баталснаас 322287,8 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээр, 33258,1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 27028,7 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Төсвийн гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс 322287,8 мянган, орон нутгийн төсвөөс 33258,1 мянган төгрөгийн, эрүүл мэндийн даатгалаас 27021,8 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 382567,8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.

Батлагдсан төсвөөс 6804,5 мянган төгрөг дутуу зарцуулсан нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1763,0 мянган, хангамж бараа материалын зардлыг 1448,0 мянган, нормативт зардлыг 1290,5 мянган, эд хогшил, урсгал засварын зардлыг 2300,9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсөвт зардлын гүйцэтгэлийг хөтөлбөр арга хэмжээний зардлын гүйцэтгэлээр авч үзвэл үндсэн мэргэжлийн тусламж, үйлчилгээний зардал 2740,5 мянган, байр ашиглалтын зардал 1802,4 мянган, нэг хүнд ногдох нормативт зардал 2261,5 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

*Хүснэгт 2.* Хөтөлбөр, арга хэмжээний зардлын гүйцэтгэл /мянган төгрөг/

| Д/Д | Хөтөлбөр, арга хэмжээний | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| | Код | Нэр | | | | |
| 1 | 71602 | Эмнэлгийн тусламж, үйлчилгээ | 382574,6 | 375770,0 | (6804,6) | 98,2 |
| 1.1 | 81603 | Үндсэн мэргэжлийн тусламж, үйлчилгээ | 329670,6 | 326930,0 | (2740,5) | 99,1 |
| 1.2 | 80109 | Байр ашиглалтын үйлчилгээ | 33258,1 | 31455,6 | (1802,4) | 94,5 |
| 1.3 | 80302 | Нэг хүнд ноогдох нормативт зардал | 19645,9 | 17384,4 | (2261,5) | 88,5 |

*Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны төсвийн хэлбэлзлийн тайлан*

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 19584,9 мянган төгрөгийн санхүүжилт орж ирснээс хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан 5 ажилтанд 19573,2 мянган төгрөгийн дэмжлэг олгож, 11,7 мянган төгрөгийг буцан төвлөрүүлсэн байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн дагуу тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээлэл байршуулахаас 147 мэдээллийг хугацаанд байршуулж, байгууллагын батлагдсан төсөв болон нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8,9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хугацаа хоцроож бусад мэдээллийг хугацаанд байршуулсан, 2 мэдээллийн байршуулах хугацаа болоогүй байна.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

*Хүснэгт 3.* www.shilendans.gov.mn цахим хуудсан дахь мэдээлэл

| Д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд нь оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 8 | 1 | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 4 | | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 36 | | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 95 | 1 | |
| | Нийт | 27 | 151 | 147 | 2 | 2 |

*Эх сурвалж:* www.shilendans.gov.mn цахим хуудас

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4 зөвлөмжийг хэрэгжүүлж, биелэлтийг 2020 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 67 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 1 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Санхүүгийн тайлангаар залруулсан алдаа байхгүй.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Тухайн санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага өгөгдөөгүй.

#### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Аймгийн Эрүүл мэндийн газраас ЭЭС -д 13114,4 мянган төгрөгийн тендерийн эм олгосноос ахлах сувилагчийн түүврээр 11575,1 мянган төгрөгийн эмийг зарцуулсан байна. ЭЭС-гийн өмнөх оны үлдэгдэл 1485,2 мянган төгрөг, тухайн оны эмийн үлдэгдэл 1539,2 мянган төгрөг, нийт 3025,1 мянган төгрөгийн эм байгааг тооллогын бүртгэлээр баталгаажуулсан. Энэхүү үлдэгдлийг тайланд орлогоор авахуулаагүй. Аймгийн хэмжээнд эм, боох материалын ханган нийлүүлэлтийн асуудал жигдрээгүй байгааг харгалзан дараагийн аудитаар авч үзэх асуудалд тусгасан болно.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

***1. Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль, эрх зүйн орчинтой холбоотой асуудал***

*1.1 Илрүүлэлт:* Шилэн дансны тухай хуулийн дагуу тайлант хугацаанд байршуулах 151 мэдээллээс байгууллагын батлагдсан төсөв, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8,9 дүгээр



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

зүйлд заасан мэдэгдлийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-дэх " Энэ хуулийн 3.1.1;.3.1.2.-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ"; 6.4-т " Энэ хуулийн 3.1.1; 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэсэн заалтыг зөрчсөн.

*1.2. Эрсдэл*: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй байх.

1.3 *Өгсөн зөвлөмж*: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" 6.4 " Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсний дагуу мэдээллийг хугацаанд нь мэдээлж хуулийг хэрэгжүүлж ажиллах.

*1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Аймгийн Санхүүгийн дотоод хяналт, аудитын албанаас хийсэн шалгалтын зөвлөмжийн дагуу мэдээллийг засаж оруулснаас хоцорсон төлөвт шилжсэн байгаа. Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан тухайн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:
АУДИТОР — Ч.ЧИМГЭЭ
Огноо: 2021.02.25

Анхан шатанд хянасан:
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР — А.ЦЭЭНЯМ
Огноо: 2021.02.25

Хоёр дахь шатанд хянасан:
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР — Б.МӨНХБАТ
Огноо: 2021.02.25

6417143544
ВЮА0067 9007423



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Хавсралт Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо | Аудитын нэр: | Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2021 | | | БНА-2021/31/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | | Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төв | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Шилэн дансны тухай хуулийн дагуу тайлант хугацаанд байршуулах 151 мэдээллээс байгууллагын батлагдсан төсөв ба нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8,9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хугацаа хоцроож мэдээлсэн | 0 | Зөвлөмж өгөх | Дарга<br>Нягтлан бодогч | С.Отгонжаргал<br>Б.Үлэмжсонин |
| | **ДҮН** | **0** | | | |

---ooOoo--